



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/287

Есөнбулаг сум

Эрхлэх асуудлын харьяалал
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1 дэх хэсэг, Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хэлтэс агентлагийн ажлын уялдаа холбоог сайжруулах, шуурхай удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэст Засаг даргын дэргэдэх агентлагийн эрхлэх асуудлын харьяаллыг хавсралтаар баталсугай.

2.Харьяа агентлагуудыг шуурхай удирдлагаар хангаж, ажлаа уялдуулан, чиглүүлж хамтран ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Эрдэнэжаргал)-д даалгасугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан 2024 оны А/243 дугаар захирамжийг хүчингүй болгосонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 09-ны өдрийн А/дүгээр
захирамжийн хавсралт

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЭЛТЭС, ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
АГЕНТЛАГИЙН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХАРЬАЛЛЫН ХУВААРЬ

№	Хэлтсийн нэр	Агентлагийн нэр
1	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Онцгой байдлын газар
2	Хууль, эрх зүйн хэлтэс	Цагдаагийн газар
		Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
		Шүүх шинжилгээний хэлтэс
		Улсын бүртгэлийн хэлтэс
		Төрийн архивын хэлтэс
3	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Орон нутгийн өмчийн газар
		Татварын газар
		Статистикийн хэлтэс
		Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба
		Гаалийн хороо
4	Нийгмийн бодлогын хэлтэс	Боловсролын газар
		Биеийн тамир, спортын газар
		Эрүүл мэндийн газар (Зоонозын өвчин судлалын албатай)
		Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
		Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
		Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар
		Нийгмийн даатгалын газар
		Эрүүл мэндийн даатгалын хэлтэс

5	Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс	Байгаль орчны газар
		Хүнс, хөдөө аж ахуйн газар
		Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
		Худалдан авах ажиллагааны газар
		Мал эмнэлгийн газар
		Стандарт, хэмжил зүйн хэлтэс
		Ус, цаг уур, орчны шинжилгээний төв
6	Салбарын хяналт, зохицуулалтын хэлтэс	Ажлын чиг үүргийн хүрээнд агентлагийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.
7	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	
8	Цэргийн штаб	

